



ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

ТАБ-ын Дарга, тэргүүлэх аудитор

Л.Жаргалсайхан

И-мэйл: jargsaihan_tuv@yahoo.com

Утас: 70272582

Факс: 01-272-22582

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер:

О.Амаржаргал

И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Утас: 70273465

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273463 99018619

И-мэйл: maits2009@yahoo.com

Аймгийн аудитын газрын хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын ордон

Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Шилэн дансны мэдээлэл
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд / ТӨВ-2016/153 /СТА-ТШЗ / аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 03 дүгээр сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитын багийн гишүүн аудитор Т.Майцэцэг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын төсвийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 01 дугаар сарын 25-нд ТАБ-т ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага аудитыг 2017 оны 03 дүгээр сарын 09-наас 2017 оны 03 дүгээр сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 15-нд Эрдэнэ сумын ИТХурлын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1."Сум, дүүргийн Хурал нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, дээд шатны Хуралд болон төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд хуулиар харьяалуулснаас бусад тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх

эрхтэй бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж хэрэгжүүлнэ” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 16 дүгээр зүйлийн 1-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурал төсөвтэй байх бөгөөд түүнийг Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрийг үндэслэн Хурлын нарийн бичгийн дарга захиран зарцуулна.” Төсвийн тухай хуулийн 16.4.14. “аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн шууд захирагч байна” гэж заасан дагуу Төв аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын нарийн бичгийн дарга төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг сум, аймгийн ИТХурлаас баталж аймгийн төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд хэрэгжиж байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нийцлийн аудитын 4200 –р стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс Төв аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн шатанд 7 горим сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй ЗДТГазрын баримт бичгийг мөрдөж байна. Бүртгэлийн асcolous програм ашигладаг байна.

Төсвийн шууд захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төв аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Дотоод хяналтыг бие дааж хэрэгжүүлээгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төв аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн шууд захирагч нь 2016 онд урсгал төсвөөс 54671.9 мянган төгрөгийн санхүүжилт авахаар батлагдсан ба гүйцэтгэлээр 54704.2 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авсан байна.

Эрдэнэ сумын ИТХурал нь 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар урсгал зардалд 56458.0 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төлөвлөгөөг 1786.1 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан. Хэтэрсэн цалингийн зардлын 1753.8 мянган төгрөгийг өр үүсгэн аймгийн төсвөөс төлж барагдуулсан. Сумын Төрийн сангаас 32.3 мянган төгрөгийг батлагдсан төсвийг хэтрүүлэн цалингийн зардалд нэмж санхүүжүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар өр барагдуулахад дээд шатнаас ирсэн 1753.8 мянган төгрөгийн санхүүжилт, зарцуулалтыг тайлагнасан байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2015 оноос “shilendans.gov.mn” цахим сайтад зохих мэдээллийг оруулсан. ҮАГ-аас нэгдсэн удирдамжаар 2016 оны 10-р сарын байдлаар хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар тус байгууллага нь нийт 25 мэдээлэл байршуулахаас 10 мэдээллийг байршуулж, 15 мэдээлэл байршуулаагүй байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлээр мөнгө хөрөнгө, бараа материал, зардал, өр төлбөр данс бүрээр хяналтын ба нарийвчилсан 7 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдэлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төв аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад цаг хугацааны хязгаардагдмал байдлаас шалтгаалан үндсэн цалингийн зардлыг дүнгээр тулган шалгасан ба мөнгөн гүйлгээний журналиас санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг сортлон шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад материаллаг хэмжээний дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн уялдаа холбоог шалгахад 1698.2 мянган төгрөгийн зардлын сонголтыг буруу сонгосноор санхүү үр дүнгийн тайланд 1698.2 мянган төгрөгийг хувьцааны ногдол ашиг гэсэн орлого эх үүсвэрээр тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.5.3.төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах; Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалаар батлагдсан НББ-ийн дансны заавар журам, Санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад алдааг хүлээн зөвшөөрч залруулсан.

2. Сумын ИТХТ-ийн тогтоолоор сумын ИТХ-ыг 3 орон тоотой байхаар баталсан. Цалин, шимтгэлийн зардал батлагдсан төлөвлөгөөнөөс 1642.1 мянган төгрөгээр хэтэрсэн. Сумын Төрийн сангаас 32.3 мянган төгрөгийг цалингийн зардалд үндсэн санхүүжилтийг хэтрүүлэн олгосон нь етайлангийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаас зөрүүтэй байгаа нь залруулагдах боломжгүй байна. Төсвийн тухай хуулийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх. 16.5.3.батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох, гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 6, 16-р зүйл заалтыг мөрдөж, батлагдсан цалингийн санд багтаан ИТХ-ын ажлын албаны бүтэц орон тоо, цалинг тогтоон ажиллах талаар зөвлөмж өгөв.

3. 1300.3 мянган төгрөгийн бичиг хэрэг, хүнсний материалыг бусад хангамжийн материал дансанд, 55.9 мянган төгрөгийн хүнсний материалыг аж ахуйн материал дансанд буруу ангилан бүртгэсэн. Бараа материалын дансанд бүртгэлгүйгээр шууд зардлын дансанд 2016.03.28-ний өдөр 153.2 мянган төгрөгийн шатахууны үнийг, 2016.03.29-ний өдөр 125.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийг тус тус бичсэн. Сангийн сайдын 2005 оны 276, 2006 оны 388-р тушаалаар батлагдсан НББ-ийн дансны заавар журам Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад 1356.2 мянган төгрөгийг залруулсан. Бараа материалын дансдаар дамжуулаагүй 278.2 мянган төгрөг залруулагдаагүй

4. Үндсэн хөрөнгийн элэгдлийг буруу тооцсоноос 392.0 мянган төгрөгөөр элэгдлийн зардлыг илүү бүртгэн тайлагнасан. НББ-ийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.2.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана. УСНББОУСтандарт , Санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэл

Шийдвэрлэсэн: Аудитын явцад алдааг хүлээн зөвшөөрч залруулсан.

Материаллаг бус алдаа зөрчил илрээгүй байна.

5. Завсарын аудитаар өгөгдсөн 1925.0 мянган төгрөгийн жолоочийн замын хуудсанд тамга дарж албажуулаагүй, замын хуудасны тооцоог нэгтгэн бодоогүй, зөрчлийг арилгуулахаар өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: АШБаримтыг үндэслэн санхүүгийн тайлан мэдээг гаргах, автомашингаар ажиллах замын маршрутыг гаргуулан батлуулж, шатахууныг олгох, шатахууны тооцоог бодож, зардлыг бүртгэж байх зөвлөмж өгөв.

6. Үндсэн хөрөнгийн Номын фонд дансанд 108.0 мянган төгрөгийн гарын авлага, эмхэтгэл сэтгүүл бүртгэсэн үлдэгдэлтэй. НББ-ийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах; Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалаар батлагдсан НББ-ийн дансны заавар журам Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, иж бүрэн байх, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Үндсэн хөрөнгийн Номын фонд дансанд бүртгэсэн 108.0 мянган төгрөгийн гарын авлага, эмхэтгэл сэтгүүлийг сумын ИТХуралд хүсэлт гаргаж, бараа материалын дансанд шилжүүлэн бүртгэн тайлагнах зөвлөмж өгөв.

7. Мөнгөн хөрөнгийн дансанд горим сорилыг хэрэгжүүлэхэд 1013.3 мянган төгрөгийн сургалтын болон бэлэн мөнгөөр авсан арга хэмжээний зардлын гардуулалтын тайлан байхгүй байна.

Шийдвэрлэсэн: Бэлэн мөнгөний зарцуулалт, гардуулалтын тайланг цаг тухай бүрд нь гаргаж санхүүгийн тайлан баримтанд хавсаргаж байх зөвлөмж өгөв.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулсан 310.5 мянган төгрөгийн алдаа байгаа болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацааны шалтгаанаас тус байгууллагын эхний 9 сарын санхүүгийн тайланд Завсарын аудит хийгдсэн тул санхүүгийн тайлангийн уялдааг болон журналийн түүвэрлэн тулган шалгав.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн Эрдэнэ сумын ИТХ-ын төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 6803.2 мянган төгрөгийн алдаа илэрсэн. Үүнээс материаллаг хэмжээний 3756.9 мянган төгрөгийн, материаллаг бус 3046.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Материаллаг хэмжээний 3446.4 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан. 310.5 мянган төгрөгийн алдаа залруулагдаагүй болно.
2. Материаллаг бус хэмжээний 3046.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байхаар зөвлөмж өгөгдсөн.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Эрдэнэ сумын ИТХурлын төсвийн 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Төв аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшин 581.6 мянган төгрөгнөөс материаллаг хэмжээний залруулагдаагүй 310.5 мянган төгрөгийн алдаа нь хэтрээгүй тул зөрчилгүй санал дүгнэлт өгөв.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, байгууллагын санал .. хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

Т.МАЙЦЭЦЭГ

2017 оны 03 сарын 14